



СОЁЛЫН ЯАМ

**О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН
ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД**

II

Улаанбаатар

2022

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд



СОЁЛЫН ЯАМ

**О.ЖАМЬЯН ГҮНГИЙН НАЙРУУЛСАН
ХЭЛ ЗҮЙН БИЧГҮҮД
II**

Эрхэлсэн:

Доктор Э.Пүрэвжав

Монгол бичгээс хөрвүүлж галигласан:

Э.Оюунтунгалаг, М.Очирцэнд

Тайлбар зүүлт хийсэн: Э.Пүрэвжав, Б.Лхагважав

ISBN: 978-9919-9852-7-1

Оршил

Тус хэл зүйн бичиг нь Онходын Жамьян гүн Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайдын албыг хаших болсноос хойших үеийн анхны зохиол бололтой. Учир нь уг зохиолын төгсгөлийн үгэнд “үүнийг Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны өвөл дунд сарын сайн өдрөө Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайд, гүн Жамьян бээр бичиж гаргавай” хэмээн бичсэн бөгөөд Олноо өргөгдсөний арван нэгдүгээр он нь 1921 он болох юм. Судар бичгийн хүрээлэнг 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан бөгөөд төгсгөлийн үгэнд өвлийн дунд сарыг дурдсан тул хүрээлэнг байгуулснаас хойш хоёр сар хүрэхгүй хугацаанд энэ зохиолыг хэвлэсэн бололтой юм.

Энэхүү зохиол нь монгол бичгийн цагаан толгойг маш товч бичсэн бөгөөд үе үсэг бүрийг нэг бүрчлэн дурдалгүй зөвхөн эгшиг үсгийг эр, эм, эрс гурваар ялган үзүүлж, эр, эм үсгийг нэгэн үгэнд хамт бичихгүй, эрс үсгийг эр, эм үсэгтэй нэгэн үгэнд хамт бичиж болно хэмээн бичжээ.

Агшилга, эгшлэг буюу эр, эм үгийн дэвсгэр “г” үсгийг хэрхэн ялгах, 11 дэвсгэр үсэгт заах, харьяалах, үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийг хэрхэн дагуулах тухай нэлээн тодорхой тайлбарлан бичсэн байдаг.

Энэ бэсрэгхэн зохиолын нэгэн өвөрмөц онцлог бол босоо “г” үсэг монгол үгэнд зөвхөн эхэнд орох бол хэвтээ “д” үсэг монгол үгэнд үгийн дунд, адагт л орох дүрэмтэй хэдий ч гадаад үгэнд үүнийг зөрчиж болно хэмээн бичжээ. Энэхүү дүрэм нь одоо ч хэвээрээ байгаа юм.

Зохиогч төгсгөлийн үгэндээ Агваандандарын “Хэлний чимэг”-ийн нэрийг дурдсан бөгөөд өмнөх *Монгол үсгийн аймаг. Анхан сурах хөвгүүдийн оюуны амыг нээх “Тодорхой толь” хэмээгдэх оршвой* зохиолоо товчилж бичсэн нь бололтой.

МОНГОЛ ҮСГИЙН ЁСНЫГ

ӨЧҮҮХЭН ТӨДИЙ ТОВЧЛОН ГАРГАСАН БАЙДАЛ

Монгол үсгийн ёсон хэмээбээс, *а о* у гурав эр хэмээх чанга, *и* эрс хэмээх саармаг, *э ө ү* эм хэмээх хөндий болохыг ялгаж мэд, бусад үсгүүдийн эр, эм, эрс гурван ялгалыг үүнээр үлгэрлэвээс мэдэж болмуй.

Эр эм хоёр үсгийг нэгэн үгэнд хавсран бичиж үл болмуй.

Эрс үсгийг эр ба, эм хоёр эгшгийн алинд боловч хавсран бичиж болох тул тийнхүү саармаг үсэг хэмээн нэрийджүхүй.

Агшлага эгшлэг хэмээх инү, “га” үсгийг эр үсэгт дэвсгэр болговоос агшлага эм ба саармаг үсэгт дэвсгэр болговоос эгшлэг хэмээмүй, үлгэрлэвээс агшлага хэмээх үсгийн *аг* ану “а”-д агшлага дэвссэн ба, эгшлэг хэмээх үсгийн “эг” инү э-д эгшлэг дэвссэн болой. Дагах үсгийн ёсон хэмээбээс, дэвсгэр үгүй үсгийг дагахыг үлгэрлэвээс

Блам-а¹,

йи йин бар дагамуй,

тамга

Дэвсгэр үсгийг дагах ёсон ану үлгэрлэвээс

ᠠ иа дэвсгэр *далай* йи йин бар

ᠡ уа дэвсгэр *дүү* йи йин бар

ᠢ на дэвсгэр *буян* и у ийар

ᠣ ба дэвсгэр *лав* и ун ийар

ᠤ га дэвсгэр *засаг, хишиг* и йин ийар

ᠮ ма дэвсгэр *ном* и ун ийар

ᠯ ла дэвсгэр *сэтгэл* и үн ийэр

ᠷ ра дэвсгэр *учир* и ун ийар

ᠰ са дэвсгэр *сэлтэс* и ун ийар

ᠷ да дэвсгэр *эд, нугуд* и үн ийэр

ᠰ нг дэвсгэр *сан* и ун ийар

Бас *-даган -дэгэн, -таган -тэгэн, -ану -инү, -дур -тур, -луга -лүгэ, -нугуд -нүгүд*, энэ бусдын эрхэд арван хоёр үсэг, ямар үсгийг дагамуй хэмээбээс, *-таган -тэгэн -тур* гурав нь *ба га ра са да* таван үсгийг дэвсгэрлэж орохуйд дагамуй. Бас дахин ялгаваас *-даган -таган -ану -луга -нугуд* энэ тав эр үсгийг дагамуй, *-дэгэн -тэгэн -инү -лүгэ -нүгүд* энэ таван эм ба саармаг үсгийг дагамуй. “да”-г тэргүүнд *та* мэт. “га”-г дунд ба адагт *да* мэт бичих заншил буй боловч бусад хэлний нэрийг энэ мэт бичихүйд “га”, “да” хоёр үсэг хоорондоо ташаарагдах гэм гарах тул “да”-г тэргүүнд, “га”-г дунд ба, адагт уг дүрээр бичиж болмуй. Үлгэрлэвээс *датагада, гүсүнгтүг, хэристос* мэт буй.

¹ Уг үгийг эхэд ваам гэсэн хэлбэрээр бичжээ. Blam-a хэмээн бичих гэсэн болов уу. Учир нь араас дагах нөхцөл нь эгшгээр төгссөн үгэнд дагуулах нөхцөл байна.

О.Жамьян гүнгийн найруулсан хэл зүйн бичгүүд

“на” дэвсгэрийг дунд оруулан бичихүйд нэг ацаг үйлдэж *жа ца да та* зэрэг үсгийн дээр бичмүй. Үлгэрлэн үзүүлбээс *они, хүнд* мэтээр бичихүйг жишиж мэдэгдэхүй. “лүгэ”, “нүгүд” хоёрын урт ацгийг хассан учир болбоос Алшаагийн Монлам Равжамба Агваандандарын зохиосон *Хэлний чимэг* хэмээх номлолд ийм бичихээр номлосны тул болой. Үүнийг Олноо өргөгдсөний арван нэгдүгээр оны өвөл дундад сарын сайн өдрөө Монгол Улсын Судар бичгийн хүрээлэнгийн эрхэлсэн сайд гүн Жамьян бээр бичиж гаргавай.

Mongyul üsüg-ün yosun-i öčüken tedüi

tobčilan γaryaysan bayidal

(1) Mongyul üsüg-ün yosun kemebesü, a o u γurba er-e kemekü čingγ-a,
i ersü kemekü sayarmay

e ö ü em-e kemekü köndeï bolqu-yi ilγaγu mete, busud üsüg-üd-ün er-e em-e
ersü γurban ilγal-i egün-iyer üliγerlebesü medeγü bolumui,

Er-e em-e qoyar üsüg-i nigen ügen-dür qabsurun bičijü ülü bolumui.

Ersü üsüg-i er-e ba, em-e qoyar üsüg-ün alin-dur bolbaču qabsurun bičijü
bolqu tula teyin-kü sayarmay üsüg kemen nereγidjüki.

Aγsily-a egsilge kemekü inü, γa üsüg-i er-e üsüg-tür debisker bolγabasu
aγsily-a em-e ba, sayarmay üsüg-tür tebisker bolγabasu egsilge kememüi,
üliγerlebesü aγsily-a kemekü üsüg-ün aγ anu a-dur aγsily-a debisügsen ba,
egsilge kemekü üsüg-ün eg inü e-dür egsilge debisügsen bolai, dayaqu üsüg-ün
yosun kemebesü, debisker-ügei üsüg-i dayaqu-yi üliγerlebesü

Baam,²

yi yin bar dayamui,

Tamay-a

(2) Debisker üsüg-i dayaqu yosun anu üliγerlebesü

ya³ ia debisker dalai yi yin bar

wa ua debisker degüü yi yin ber

na na debisker buyan i u iyar

ba ba debisker lab i un iyar

ga γa debisker γasay kesig i un /ün/ iyar /iyer/

ma ma debisker nom i un iyar

la la debisker sedkil i ün iyer

ra ra debisker učir i un iyar

sa sa debisker seltes i ün iyar

² Влам-а

³ Үүнээс хойших мөр бүрийн эхний галиг нь төвөд үсгийн галиг, арын галиг нь монгол бичгийн галиг болно.


da da debisker ed nuγud i ün /un/ iyer /iyar/

nga ng debisker sang i un iyar metü bolai.

Basa daγan degen, taγan tegen, anu inü, dur /dür/ tur /tür/, luγ-a lüge, nuγud nüγüd, ene busud-un erketü arban qoyar üsüg, yambar üsüg-i daγamui kemebesü, taγan tegen tur /tür/ γurba anu ba γa ra sa da tabun üsüg-i debiskerlejü oruqui-dur daγamui. Daγan degen dur /dür/ γurba anu busud debisker üsüg-üd ba, debisker-ügei üsüg bügüde-yi daγamui. Basa dakin ilγabasu daγan taγan anu luγ-a nuγud ene tabu er-e üsüg-i daγamui, degen tegen inü lüge nüγüd ene tabun em-e ba saγarmag üsüg-i daγamui.

(3) da-yi terigün-dür ta metü. ta-yi dumda ba aday-tur da metü bičikü jangsil bui bolbaču busud kelen-ü ner-e-yi ene metü bičiküi-dür ta da qoyar üsüg qoyurundu-ban tasiyaraydaqu gem γarqu tula da-yi terigün-dür, ta-yi dumda ba, aday-tur uy düri-ber bičijü bolumui, üliγerlebesü dataγada küsüngtüγ keristos metü bui.

na debisker-i dumda oruyulun bičiküi-dür nige ačuγ uiledčü ja ča da ta jerge üsüg-ün deger-e bičmüi, üliγerlen üjögülbesü onča күндү metü-ber bičiküi-yi jisiγü medegdeküi, lüge nüγüd qoyar-un urtu ačuγ-i qasuγsan učir bolbasu alaša-yin monlam Rabjamba ngagwangdandar-un jokiyaysan “Kelen-ü čimig” kemekü nomlal-dur eyimü bičikü-ber nomlaysan-u tula bolai. Egün-i olan-a ergügdegsen-ü arban nigedüger on-u ebül dumdadu sar-a-yin sayin edür-e Mongγul ulus-un Sudur bičig-ün küriyeleng-ün erkilegsen sayid güng jamiang ber bičijü γaryabai.



1. Өгөгдөл
 2. Өгөгдөл
 3. Өгөгдөл
 4. Өгөгдөл
 5. Өгөгдөл
 6. Өгөгдөл
 7. Өгөгдөл
 8. Өгөгдөл
 9. Өгөгдөл
 10. Өгөгдөл

1. Өгөгдөл
 2. Өгөгдөл
 3. Өгөгдөл
 4. Өгөгдөл
 5. Өгөгдөл
 6. Өгөгдөл
 7. Өгөгдөл
 8. Өгөгдөл
 9. Өгөгдөл
 10. Өгөгдөл